



МОНГОЛ УЛСЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 05 дүгээр сарын 17-ны өдөр

№02

Улаанбаатар хот

Мэдээллээр хангах тухай

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.6.4 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дүрмийн 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын “Цагаан ном 2021”-д гишүүдээс гаргасан санал зөвлөмжийг тусгаж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулж, иргэдийг мэдээллээр хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбоо (Д.Наранпүрэв)-т тус тус даалгасугай

2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар Монгол Улсын Их хуралд 2022 оны 2 дугаар улиралд багтаан танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг салбар тус бүрээр хангаж ажиллахыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА,
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

Л.ХАЛТАР

0800000002